

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар

№	Үндсэн зарчим	Авбал зохих нийт оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11	91.6%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	5	83.3%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	83.3%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	87.5%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	90%
Нэгдсэн дүн		72	71	98.6%

Тайлбар: 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар “ЛэндМН ББСБ” ХК-ийн зүгээс "Компанийн засаглалын кодекс"-ийг 98.6%- тай хэрэгжүүлэн ажиллаж, “Засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд хэмээн үнэлж байна.

**2. “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ**

НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна		
	Үнэлгээ	2025.06.20-ны өдрийн байдлаар ЛэндМН-ээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	2
2	1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.	2
3	1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.	1 Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн ажлын гүйцэтгэлтэй холбоотой мэдээллүүдийг тусгасан ба Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2024 онд гаргасан “ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх гарын авлага”-ын дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, гишүүдийн 2025 оны хагас жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх бэлтгэл ажлыг зохион байгуулж байна. Тус үнэлгээг 2025 оны 3 дугаар улиралд багтаан хийж, Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлнэ.
4	1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.	2

5	<i>1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	2	Компанийн ТУЗ-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн Ээлжит хурлаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн сургалтын төлөвлөгөө”-г хэлэлцэж баталсан болно. Тус төлөвлөгөөний дагуу ТУЗ-ийн сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.
6	<i>1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	2	ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын 2024 оны үйл ажиллагааны тайланг бэлтгэж, Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлсэн.
ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ			
7	<i>2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	2	2025 онд шинээр сонгогдсон ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, комплаенсын ажилтны мэдээллийг шинэчлэн, анкетыг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлсэн.
8	<i>2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	2	
9	<i>2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх</i>	2	

	удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.		
10	2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	2	
11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	2	
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн байдлыг хангана			
12	3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	2	
13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекс заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	2	Компанийн албан ёсны цахим хуудас болох Home - LendMN -д Компанийн үйл ажиллагааны үндсэн мэдээлэл болон дараах засаглалын бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг байршуулаад байна. Үүнд: - Ёс зүйн дүрэм журам - Харилцагчийг хамгаалах журам - Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн бодлого - Эрсдэлийн удирдлагын бодлого - Хувийн мэдээллийн бодлого

			- Залгамж халааны бодлого - Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	2	
ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана			
15	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	2	
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	2	
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	2	Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайланд дотоод аудитын талаарх мэдээ мэдээллийг тусгахдаа хийж хэрэгжүүлсэн ажил үүргийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй тусгана.
ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина			

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	2	
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	2	Компанийн ТУЗ нь дэргэдээ Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хороо, Аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх хороо болон Цалин, урамшууллын хороо гэх 4 хороотой болно.
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	2	
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	2	
ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна			
22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	2	
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх	2	

	<i>шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.</i>		
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>	2	ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооноос Гүйцэтгэх захирлын цалин урамшууллыг олгохдоо дараах гүйцэтгэлийн шалгууруудыг тавьж байгаа болно. Үүнд: 1. Санхүүгийн үзүүлэлт- Багц, Орлого, Ашиг, Чанаргүй зээлийн багц 2. Санхүүгийн бус үзүүлэлт №1- Ажиллагсдын сэтгэл ханамж 3. Санхүүгийн бус үзүүлэлт №2- Компанийн олон нийт болон салбар дундах нэр хүнд Компани тус гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг 2025 оны жилийн үйл ажиллагааны тайланд оруулах болно.
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ			
25	<i>7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>	2	
26	<i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>	2	
27	<i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>	2	Компанийн албан ёсны цахим хуудас болох Home - LendMN -д Компанийн үйл ажиллагааны үндсэн мэдээлэл болон дараах засаглалын бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг байршуулаад байна. Үүнд:

			- Ёс зүйн дүрэм журам - Харилцагчийг хамгаалах журам - Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн бодлого - Эрсдэлийн удирдлагын бодлого - Хувийн мэдээллийн бодлого - Залгамж халааны бодлого - Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	2	
НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно			
29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	2	
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i>	2	
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>	2	
ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана			

32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	2	Компанийн албан ёсны цахим хуудас болох Home - LendMN -д Компанийн үйл ажиллагааны үндсэн мэдээлэл болон дараах засаглалын бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг байршуулаад байна. Үүнд: - Ёс зүйн дүрэм журам - Харилцагчийг хамгаалах журам - Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн бодлого - Эрсдэлийн удирдлагын бодлого - Хувийн мэдээллийн бодлого - Залгамж халааны бодлого - Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	2	
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	2	
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	2	
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	2	Компани нь ТУЗ-өөс зөвшөөрөл олгосон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээг тухай бүр “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-аар дамжуулан нийтэд мэдээлж ажилладаг. Цаашид бид сонирхлын зөрчилтэй хэлцлийн дүн тоо, мэдээг улирал тутам СЗХ-нд хүргүүлж ажиллана.